



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017 02. № 3/226
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Эгийн голын усан цахилгаан станц” төслийн нэгжийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

“Эгийн голын усан цахилгаан станц” төслийн нэгжийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.


Аудитаар санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Эгийн голын усан цахилгаан станц" төслийн нэгжийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЭНХЗАЯА

УХА0122



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

“ЭГИЙН ГОЛЫН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨСЛИЙН НЭГЖИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах
хаягаар харилцана уу:**

ТАБ-ын Тэргүүлэх аудитор: С.Энхзаяа

Утас: 261663

Цахим хаяг: enkhzaya@audit.gov.mn

Аудитын менежер: Н.Золзаяа

Утас: 260512

Цахим хаяг: zolzaya@audit.gov.mn

Аудитор: Ц.Сугармаа

Утас: 99151254

Цахим хаяг: sugarmaa23@gmail.com

Компанийн хаяг: “И Эс Эс Эс Аудит” ХХК

Байршил: СБД, 1-р хороо Жамьяан гүний
гудамж-5, Ар Монгол Травэлийн байр

Цахим хаяг: esss.audit@gmail.com

2017 оны 2 дугаар сар

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “ЭГУЦС” төслийн нэгжийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд САГ-2017/58/СТА-ТӨҮГ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

“ЭГУЦС” төслийн нэгжийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төслийн захирал санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“ЭГУЦС” төслийн нэгжийн 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 20-ны хооронд хийхээр төлөвлөж, тус компанийн захирал буюу мэргэшсэн нягтлан бодогч, мэргэшсэн дотоод аудитор Ц.Сугармаа хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/, /ТАБ-СТА-А-10/

“ЭГУЦС” төслийн нэгжийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 20-нд тус компанид ирүүлсэн тул хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

Тус компани аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 20-ноос 2017 оны 2 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 20-ны дотор УАГ-ын холбогдох албан тушаалтнуудаар хянуулсны дараагаар дүгнэлтийг албан ёсоор болгож, “ЭГУЦС” төслийн нэгжийн удирдлагад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“ЭГУЦС” төслийн нэгжийн удирдлага нь Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн албаны тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын

санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“ЭГУЦС” төслийн нэгжийн зорилго нь МУ-ын Засгийн газрын 2013 оны 375 тоот тогтоолоор Монгол Улсын төвийн эрчим хүчний системийн горимын тогтвортой ажиллагааг дээшлүүлэх, импортын эрчим хүчний хамаарлаас гарах зорилгоор Эгийн голын усан цахилгаан станцыг барьж ашиглалтад оруулахад” чиглэгдэж байна.

“ЭГУЦС” төслийн нэгжийн төсвийн 2016 оны төсвийг Эрчим хүчний яам, Хөгжлийн банкны зээлээр санхүүжилтийн эрх олгож, үйл ажиллагааг санхүүжүүлж ирсэн байна.

“ЭГУЦС” төсөлтэй холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Төрийн аудитын тухай хууль Авилгатай тэмцэх тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

“ЭГУЦС” төслийн нэгжийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “ЭГУЦС” төслийн нэгжийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төслийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжуулав. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорилыг данс бүрээр түүвэрлэн гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “ЭГУЦС” төслийн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн CTS System 5.0 програмыг ашиглаж, санхүүгийн тайланг гаргаж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн хувьд Эрчим

хүчний яамны санхүү үйл ажиллагаанд мөрдөж буй баримт бичгийг баримталж ажиллаж байна.

“ЭГУЦС” төслийн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Материаллаг түвшинг тооцохдоо төлөвлөлтийн шатанд төслийн нийт зардлын гүйцэтгэлээс 1 хувиар буюу 14012.1 мянган төгрөгөөр урьдчилан тооцсон бөгөөд гүйцэтгэлийн шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзэв.

Тав. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Сангийн яам, Эрчим хүчний яам болон Хөгжлийн банкны хамтран хийсэн зээлийн гэрээний дагуу үйл ажиллагаа, санхүүжүүлэх хөрөнгийг гаргаж байгаа бөгөөд гүйцэтгэлд давхар хяналт тавьж байна. 2017 оны 1 дүгээр сард Эрчим хүчний яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас төслийн санхүүжилтийн зарцуулалт, төслийн сонгон шалгаруулалт, гэрээний хэрэгжилт, гүйцэтгэлийн чанар, төслийн үр дүнд шалгалт хийжээ.

Шалгалтаар ажил гүйцэтгэгч зарим аж ахуйн нэгж байгууллагатай хийсэн гэрээний дагуу өгсөн санхүүжилтыг хийсэн тухай бүрт нь дүгнэж тайлан гаргаагүй, техник, судалгааны ажлуудыг бүрэн хийгээгүй, зорилгоо хангалтгүй биелүүлсэн, зарим хууль тогтоомжийн заалтуудыг зөрчсөн зэрэг зөрчил дутагдлууд гарсан байна.

Дотоод хяналтыг сайжруулах талаар санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөх болно.

Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 онд тус нэгж нь Хөгжлийн банкны зээлийн хүрээнд батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжилтийн эрх нээж, зээлийн гэрээний дагуу санхүүжүүлэх боломжгүйгээс тайлант жилд 2 удаа санхүүжилт авчээ. Уг төслийг БНХАУ-ын хөнгөлттэй зээлээр санхүүжүүлэх шийдвэр гарсан боловч шийдвэрлэгдээгүй, төслийг санхүүжүүлэх асуудал хүндрэлтэй байна.

“ЭГУЦС” төслийн нэгж нь 2016 онд хөгжлийн банкны зээлээр урсгал зардалд нийт 2927.5 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 1633.3 сая төгрөгийг авч, зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл 1294.2 сая төгрөг байна.

Долоо. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2016 оны нийт зээлийн хөрөнгөөр баталсан төсөв болон гүйцэтгэлийн талаарх мэдээлэл, ажлын гүйцэтгэл, бусад холбогдох мэдээллийн талаар вэбсайт хуудсанд байршуулсан бөгөөд яамны ХШУДАГ-аас шилэн дансны мэдээлэлд үнэлэлт дүгнэлт өгсөн байна.

Тайлант жилд шилэн дансны мэдээлэлд 5.0 сая төгрөгөөс дээш томилолтын зардал, өмнөх оны санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангууд оруулсан байна.

Найм. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын данс бүрээр эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд орлого, зарлагын дансны зүйл ангиар задалвал нийт 14 нарийвчилсан горим, сорил хийж дүгнэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Аудитаар гаргасан доорх эрсдлүүд нь зээлийн хөрөнгийг хэмнэлтгүй зарцуулсан, дээд газраас хийх дотоод хяналтыг сулруулж, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүргэж болзошгүй юм.

Ес. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

“ЭГУЦС” төслийн нэгжийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, зөвлөх үйлчилгээний зардал, бусад орлого, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, төлбөр хураамж, сургалт семинар зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын буюу зээлээр санхүүжүүлсэн тул зээлийн дүн, хүүгийн орлого болон бусад орлогын буюу банкны хүүгийн орлогын түүвэр 100 хувь, мөнгөн хөрөнгийн 80 хувь, нийт зардлын 50-60 хувийг тус тус түүвэрчилсэн сорил хэрэгжүүлсэн болно.

“ЭГУЦС” төслийн нэгж нь цахилгаан станц барьж байгуулахад шаардагдах 703.4 сая.ам долларын хөрөнгийг олон улсын банк, санхүүгийн зах зээлээс босгох ажлыг зохион байгуулах үндсэн зорилготой бөгөөд ийн үйл ажиллагаа 2013 онд эхэлсэн бөгөөд олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын шаардлага хангасан төслийн баримт бичиг бэлтгэх, боломжит хөрөнгө оруулагчидтай хэлэлцээр хийх, шаардагдах бусад техникийн судалгааны ажлуудыг хийж, гүйцэтгэх зорилготой

бөгөөд одоогийн байдлаар энэхүү төслийн ажлын явц, цаашид чухам төсөл үргэлжлэх, үргэлжлүүлэхгүй тухайд тодорхойгүй байна.

Төсөл хэрэгжиж буй энэхүү хугацаанд төслийн үйл ажиллагаанд тавьсан зорилт, зорилгодоо хэрхэн хүрсэн, хүрээгүй байдлыг үнэлсэн дүгнэлт, үнэлгээний өгсөн баримт бичиг алга байна.

Тайлант жилийн байдлаар өссөн дүнгээр төслийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд Хөгжлийн банкнаас нийт 22.6 тэр бум төгрөгийн зээл олгосон бөгөөд үүнээс хүүгийн өглөгт 2.3 тэр бум төгрөг төлөхөөр байна.

Төслийн нэгж үндсэн орлого гэж байхгүй, харилцах дансны хүүгийн орлогоор 9.2 сая төгрөгийн, харин гадаад валютын ханшийн зөрүүний олзоор 74.9 сая төгрөгийг татварын бус орлогоор тус тус хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд илэрхийлсэн болно.

Арав. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад дараах материаллаг бус алдаа илэрлээ. /ТАБ-СТА-В-4/ Үүнд:

1. Түр журмын 12.1-д Төслийн хэрэгжилтийн явцад хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг хагас, бүтэн жилээр, дунд хугацааны үнэлгээг дунд хугацаанд, төслийн эцсийн шатанд үнэлгээг төсөл хэрэгжүүлэгч байгууллага зохион байгуулж хийхээр заасан байдаг. Гэтэл Төслийн нэгжийн үнэлгээг хагас, бүтэн жилээр хийж, үнэлж дүгнэлт гаргаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөл хэрэгжүүлэгч байгууллага журмын дагуу ажлын хэсэг томилж, төслийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж, тайланг гаргах

2. Хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан МУ-ын ЗГ-ын гаргасан үнэт цаасны хөрөнгөөр санхүүжих төслүүдийн төслийн удирдлага, зохион байгуулалт, оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлж, төслүүдийн хэрэгжилтэд хяналт тавих, үйл ажиллагааг нь зохицуулахад нийтлэг баримталдаг журмыг ЭЗХ-ийн сайдын 2013 оны 29 дүгээр түр журмаар зохицуулсан байдаг. Гэтэл ЭЗХЯам 2015 онд татан буугдсан тул цаашид төслийн нэгжийн үйл ажиллагаа болон бусад эрх, үүргийг зохицуулсан журмыг шинэчлэх шаардлагатай болсон байна

Шийдвэрлэсэн нь: МУ-ын ЗГ-ын гаргасан үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх төслүүдийн нэгжийн үйл ажиллагаа болон бусад эрх, үүргийг зохицуулсан эрхийн актыг шинэчлэн боловсруулах

3. Төслийн нэгжийн удирдлагаас “Камдер” ХХК-тай хийсэн гэрээгээр 385 м2 талбай бүхий оффисын талбайг нэг метр квадрат нь сард 35.000 төгрөгөөр түрээсэлж, нийт 161.7 сая төгрөг төлж байна. Нийт ажилчдыг тайлант жилд цомтгож цөөн болгосон бөгөөд зээлийн хөрөнгийн үр ашиггүй зардлыг бууруулах зорилгоор оффисын түрээсийн зардлыг багасгаж, Төрийн өмчийн байгууллагуудын илүүдэл талбайг бусдад түрээслүүлэхэд баримталж байгаа ТӨХ-ны тогтоолын жишиг үнэтэй уялдуулан тогтоож, зардлыг бууруулах арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй

Шийдвэрлэсэн нь: Түрээсийн зардлыг бууруулж, арвилан хэмнэлтийн горимд шилжин ажиллах арга хэмжээ авах

Арван нэг. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын

талаарх тайлбар:

Аудитын явцад залруулах материаллаг алдаа тогтоогдоогүй болно.

Арван хоёр. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Төсөл эхэлсэн цагаасаа хойш Хөгжлийн банкны зээлээр нийт 22.6 тэр бум төгрөгийг авч зарцуулсан бөгөөд цаашид төслийг үргэлжлүүлэх, эс үргэлжлүүлэх талаар шийдвэрийг Монгол Улсын Засгийн газар болон холбогдох дээд шатны байгууллагын шийдвэрийг харгалзан үзэх шаардлага гарч байна.

Арван гурав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

“ЭГУЦС” төслийн нэгжийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үзэж, дүгнэх болно.

Арван дөрөв. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төслийн нэгжийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 161.7 сая төгрөгийн түрээсийн төлбөр төлж, зээлийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарж байгаа алдаа, зөрчил илэрсэн тул зөвлөмж өгөв.

Арван тав. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх аудитаар 2 зөвлөмж өгч, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. Зөвлөмжийн биелэлтийн талаар арга хэмжээ авч ажилласан талаар тайлбарыг 2017 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 29 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.

Арван зургаа. Зөвлөмж:

Менежментийн захидалд материаллаг бус алдаа, зөрчлийн талаар бичиж, зөвлөмж өгсөн болно.

Арван долоо. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Зөрчилгүй санал дүгнэлт

“ЭГУЦС” төслийн нэгжийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон тодруулга, тэмдэглэлийг тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан болон бусад холбогдох хавсралт хуудсуудыг тус тус хавсаргав.

“ЭГИЙН ГОЛЫН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨСЛИЙН НЭГЖИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Дотоод хяналт үнэлгээний
талаар.....3

Асуудал 2

Хууль эрх зүйн талаар.....4

Асуудал 3

Зардлын талаар.....5

2017 оны 2 дугаар сар

Менежментийн захидал

Бид аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Эгийн голын усан цахилгаан станц” төслийн нэгжийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Тус компани энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой өгч байгаа бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “ЭГУЦС” төслийн нэгжийн удирдлага болон санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 2: Хууль эрх зүйн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан МУ-ын ЗГ-ын гаргасан үнэт цаасны хөрөнгөөр санхүүжих төслүүдийн төслийн удирдлага, зохион байгуулалт, оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлж, төслүүдийн хэрэгжилтэд хяналт тавих, үйл ажиллагааг нь зохицуулахад нийтлэг баримталдаг журмыг ЭЗХ-ийн сайдын 2013 оны 29 дүгээр түр журмаар зохицуулсан байдаг. Гэтэл ЭЗХЯам 2015 онд татан буугдсан тул цаашид төслийн нэгжийн үйл ажиллагаа болон бусад эрх, үүргийг зохицуулсан журмыг шинэчлэх шаардлагатай болсон байна

ҮАГ-ын зөвлөмж

МУ-ын ЗГ-ын гаргасан үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх төслүүдийн нэгжийн үйл ажиллагаа болон бусад эрх, үүргийг зохицуулсан эрхийн актыг шинэчлэн боловсруулах

Эрсдэлүүд

Холбогдох хууль, эрх зүйн акт зөрчилдөх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг Асуудлын бүртгэлээр баталгаажуулсан болно.

Асуудал 1: Дотоод хяналт үнэлгээни й талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
--	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Түр журмын 12.1-д Төслийн хэрэгжилтийн явцад хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг хагас, бүтэн жилээр, дунд хугацааны үнэлгээг дунд хугацаанд, төслийн эцсийн шатанд үнэлгээг төсөл хэрэгжүүлэгч байгууллага зохион байгуулж хийхээр заасан байдаг. Гэтэл Төслийн нэгжийн үнэлгээг хагас, бүтэн жилээр хийж, үнэлж дүгнэлт гаргаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага журмын дагуу ажлын хэсэг томилж, төслийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж, тайланг гаргах

Эрсдэлүүд

Хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийхгүй байх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг Асуудлын бүртгэлээр баталгаажуулсан болно.

ҮАГ-ын ажиглалт

Төслийн нэгжийн удирдлагаас “Камдер” ХХК-тай хийсэн гэрээгээр 385 м2 талбай бүхий оффисын талбайг нэг метр квадрат нь сард 35.000 төгрөгөөр түрээсэлж, нийт 161.7 сая төгрөг төлж байна. Нийт ажилчдыг тайлант жилд цомтгож цөөн болгосон бөгөөд зээлийн хөрөнгийн үр ашиггүй зардлыг бууруулах зорилгоор оффисын түрээсийн зардлыг багасгаж, Төрийн өмчийн байгууллагуудын илүүдэл талбайг бусдад түрээслүүлэхэд баримталж байгаа ТӨХ-ны тогтоолын жишиг үнэтэй уялдуулан тогтоож, зардлыг бууруулах арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж арвилан хэмнэлттэй ажиллаагүй байх

ҮАГ-ын зөвлөмж

Түрээсийн зардлыг бууруулах арга хэмжээ авч ажиллах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг Асуудлын бүртгэлээр баталгаажуулсан болно.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

төгрөгөөр

Код	Балансын зүйл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	3	1,094,731,340.41	422,870,398.28
	Кассад байгаа бэлэн мөнгө		2,288,920.00	3,342,194.50
	Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/		14,907,048.63	400,082,982.85
	Банкинд байгаа бэлэн мөнгө/гадаад валютаар/		1,077,535,371.78	19,445,220.93
	Богино хугацаат хадгаламж		0.00	0.00
	Замд яваа мөнгөн хөрөнгө		0.00	0.00
	АВЛАГА	4	850,000.00	850,000.00
	Төлбөртэй үйлчилгээний авлага		0.00	0.00
	Бусад авлага		850,000.00	850,000.00
	УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР		9,622,512,475.73	10,994,554,859.20
	Урьдчилгаа тооцоо		14,960,000.00	16,130,176.00
	Урьдчилж гарсан зардал		16,009,725.00	3,902,400.00
	Урьдчилж гарсан зардал ТӨСӨЛ		9,591,542,750.73	10,974,522,283.20
	БАРАА МАТЕРИАЛ	5	21,485,191.80	21,518,278.08
	Түүхий эд материал		732,460.00	479,305.00
	Дуусаагүй үйлдвэрлэл		0.00	0.00
	Бэлэн бүтээгдэхүүн			
	Хангамжийн материал		10,616,048.60	8,915,516.60
	Түлш, шатах тослох материал		214,576.20	23,349.48
	Бусад /Авто сэлбэг/		9,922,107.00	12,100,107.00
	НӨӨЦИЙН БАРАА		0.00	0.00
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		10,739,579,007.94	11,439,793,535.56
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		0.00	0.00
	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6	607,026,562.95	464,605,074.04
	Биет хөрөнгө		600,048,021.20	460,241,532.28
	Барилга, байгууламж		0.00	0.00
	Хуримтлагдсан элэгдэл		0.00	0.00
	Авто- тээврийн хэрэгсэл		632,578,000.00	632,578,000.00
	Хуримтлагдсан элэгдэл		-210,174,610.98	-315,604,277.58
	Машин, тоног төхөөрөмж		140,475,075.00	143,225,075.00
	Хуримтлагдсан элэгдэл		-53,837,143.39	-88,450,496.60
	Тавилга, аж ахуйн эд хогшил		97,127,559.00	97,468,559.00
	Хуримтлагдсан элэгдэл		-19,362,667.83	-29,078,272.30
	Батлан хамгаалахын зориулалттай тоног төхөөрөмж		0.00	0.00
	Хуримтлагдсан элэгдэл		0.00	0.00
	Түүх соёлын дурсгалт зүйлс		0.00	0.00
	Хуримтлагдсан элэгдэл		0.00	0.00
	Номын фонд		0.00	0.00

Хуримтлагдсан элэгдэл		0.00	0.00
Бусад үндсэн хөрөнгө		14,358,792.00	24,358,792.00
Хуримтлагдсан элэгдэл		-1,116,982.60	-4,255,847.24
Дуусаагүй барилга, байгууламж		0.00	0.00
Биет бус хөрөнгө		6,978,541.75	4,363,541.76
Программ хангамж		10,060,000.00	10,860,000.00
Хуримтлагдсан элэгдэл		-4,893,958.25	-7,558,958.24
Бусад биет бус хөрөнгө		3,000,000.00	3,000,000.00
Хуримтлагдсан элэгдэл		-1,187,500.00	-1,937,500.00
БУСАД ХӨРӨНГӨ		0.00	0.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		607,026,562.95	464,605,074.04
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		11,346,605,570.89	11,904,398,609.60
Богино хугацаат өр төлбөр		0.00	0.00
Өглөг		1,576,350,581.09	2,480,015,077.51
Ажиллагчидтай холбогдсон өглөг		0.00	0.00
Бараа үйлчилгээний зардлын өглөг		0.00	0.00
Татаас, санхүүжилтийн өглөг		0.00	0.00
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг		0.00	0.00
Зээлийн хүүгийн өглөг		1,064,789,203.00	2,339,890,236.17
Бусад өглөг		511,561,378.09	140,124,841.34
Урьдчилж орсон орлого		0.00	0.00
Урьдчилгаа- Төсвийн татаас		0.00	0.00
Бусад урьдчилж орсон орлого		0.00	0.00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	7	1,576,350,581.09	2,480,015,077.51
Урт хугацаат зээл, зээлийн хүү		14,966,327,035.42	20,300,374,159.56
УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН	8	14,966,327,035.42	20,300,374,159.56
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		16,542,677,616.51	22,780,389,237.07
Засгийн газрын сан		0.00	0.00
Орон нутгийн сан		0.00	0.00
Хуримтлагдсан үр дүн		-5,196,072,045.62	-10,875,990,627.47
Өмнөх үеийн үр дүн		-2,981,455,400.35	-5,196,072,045.62
Тайлант үеийн үр дүн		-2,214,616,645.27	-5,679,918,581.85
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		0.00	0.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН		-5,196,072,045.62	-10,875,990,627.47
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН		11,346,605,570.89	11,904,398,609.60

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	1	24,953,265.19	9,291,817.92
	Татаас санхүүжилтын орлого			
	Улсын төсвөөс		-	-
	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО			-
	Харилцах дансны хүүгийн орлого		22,190,695.89	8,322,922.77
	Бусад орлого		2,762,569.30	968,895.15
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		24,953,265.19	9,291,817.92
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	2	2,001,452,967.71	0.00
	УРСГАЛ ЗАРДАЛ		2,001,452,967.71	1,694,896,361.73
	АЖИЛЛАГСАДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ		1,349,863,393.05	1,085,299,297.80
	Цалин		944,530,677.73	806,595,331.33
	Урамшуулал		257,038,751.27	163,983,333.33
	ТУХ-ны гишүүдийн цалин		7,840,000.00	
	АЖИЛ ОЛГОГЧООС Төлөх НДШ		140,453,964.05	114,720,633.14
	Тэтгэврийн даатгалын шимтгэл		88,834,541.00	72,994,543.37
	Тэтгэмжийн даатгалын шимтгэл		11,645,442.00	9,030,115.56
	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл		2,481,874.05	2,026,998.21
	ҮОМШӨвчний даатгалын шимтгэл		12,673,368.00	10,398,992.00
	Эрүүл мэндийн даатгалын хураамж		24,818,739.00	20,269,984.00
	БАЙР АШИГЛАХТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ		172,884,411.65	173,456,649.45
	Байрны түрээс		172,884,411.65	173,456,649.45
	ХАНГАМЖ БАРАА МАТЕРИАЛ		107,204,871.76	119,242,433.85
	Бичиг хэрэг		15,422,382.50	11,831,396.00
	Тээвэр шатахуун		65,867,526.02	72,176,541.52
	Шуудан холбооны зардал		21,256,373.24	23,373,134.33
	Хангамж, БүТЭЗ, ахуйн эд зүйл		4,658,590.00	11,861,362.00
	ТОМИЛОЛТЫН ЗАРДАЛ		160,602,481.45	73,960,414.80
	Гадаад албан томилолт		117,617,939.65	47,865,736.45
	Дотоод албан томилолт		42,984,541.80	26,094,678.35

БУСДААР ГҮЙЦЭТГҮҮЛСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР	.	30,146,918.55	51,818,444.02
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		2,000,000.00	8,000,000.00
Мэдээлэл сурталчилгааны зардал		21,698,573.15	43,696,875.00
Банкны үйлчилгээний хураамж		601,938.40	121,569.02
Мэдээлэл технологийн зардал		5,846,407.00	0.00
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ЗАРДАЛ		31,745,499.25	32,806,632.90
Сургалт семинарын зардал		24,469,284.25	27,235,611.00
Бусад зардал		7,276,215.00	5,571,021.90
АЖИЛ ОЛГОГЧООС ӨГӨХ ТЭТГЭМЖ, ДЭМЖЛЭГ		500,000.00	2,000,000.00
Нэг удаагийн тэтгэмж		500,000.00	2,000,000.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		148,505,392.00	156,312,488.91
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		148,505,392.00	156,312,488.91
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)		2,001,452,967.71	1,694,896,361.73
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III) = (I) - (II)		(1,976,499,702.52)	-1,685,604,543.81
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		-	0.00
Гадаад валютын ханшын зөрүүгийн олз (бодит)		4,910,352.20	6,799,293.20
Гадаад валютын ханшын зөрүүгийн олз (бодит бус)		307,669,481.10	785,062,219.96
Үндсэн хөрөнгө худалдсаны олз		-	0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)		312,579,833.30	791,861,513.16
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		-	0.00
Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз (бодит бус)		903,642,187.96	4,786,026,151.20
Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз (бодит)		3,274,239.39	149,400.00
Хөрөнгө худалдсаны гарз		-	
Хүүгийн зардал		(356,219,651.30)	0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛЫН ДҮН (V)		550,696,776.05	4,786,175,551.20
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН		(2,214,616,645.27)	-5,679,918,581.85

АУДИТ ХИЙГДСЭН/ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2015 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
...	-	-	-	-
...	-	-	-	-
..	-	-	-	-
2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	(5,196,072,045.62)	(5,196,072,045.62)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(5,679,918,581.85)	(5,679,918,581.85)
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	(10,875,990,627.47)	(10,875,990,627.47)

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		152,639,365.28	83,220,710.00
	Харилцах дансны хүүгийн орлого		22,190,695.89	8,322,922.77
	Бусад орлого		1,821,400.00	-
	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		128,627,269.39	74,897,787.23
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1	152,639,365.28	83,220,710.00
	АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ		1,349,863,393.25	1,085,299,297.25
	Цалин		944,530,677.73	806,595,330.81
	Урамшуулал		257,038,751.27	163,983,333.33
	audit		7,840,000.00	-
	Нийгмийн хамгааллын шимтгэл		140,453,964.25	114,720,633.11
	Тэтгэврийн даатгалын шимтгэл		88,834,540.00	72,994,541.90
	Тэтгэмжийн даатгалын шимтгэл		11,645,444.00	9,030,116.28
	Төмшөгчийн даатгалын шимтгэл		2,481,874.25	2,026,999.36
	Төмшөгчийн даатгалын шимтгэл		12,673,368.00	10,398,991.75
	Эрүүл мэндийн даатгалын хураамж		24,818,738.00	20,269,983.82
	БАЙР АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ		172,451,645.41	173,957,062.20
	Байрны түрээс		172,451,645.41	173,957,062.20
	ХАНГАМЖ, БАРАА МАТЕРИАЛЫН ЗАРДАЛ		108,985,600.77	121,223,722.85
	Бичиг хэргийн материал		14,549,292.50	11,838,241.00
	Гэвэр, шатахууны зардал		66,655,685.10	75,201,396.79
	Шуудан холбооны зардал		21,681,503.17	24,023,255.06
	Хангамж, ахуйн эд зүйлс		6,099,120.00	10,160,830.00
	ТОМИЛОЛТЫН ЗАРДАЛ		160,602,480.05	73,960,414.66
	Гадаад албан томилолт		117,617,939.05	47,865,736.45
	Дотоод албан томилолт		42,984,541.00	26,094,678.21
	БУСДААР ГҮЙЦЭТГҮҮЛСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР	-	43,351,042.55	34,614,319.02
	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		2,000,000.00	4,000,000.00
	Мэдээлэл сурталчилгааны зардал		34,902,697.15	30,492,750.00

	Банкны үйлчилгээний хураамж		601,938.40	121,569.02
	Мэдээдэд технологийн зардал		5,846,407.00	0.00
	БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ЗАРДАЛ		114,864,132.06	53,256,888.03
	Сургалт семинарын зардал		24,469,283.25	27,235,611.00
	Бусад зардал		7,236,215.00	5,611,021.90
	Балжирт ханшийн зөрүүгийн алдагдал		83,158,633.81	20,410,255.13
	АЖИЛ ОЛГОГЧООС ӨГӨХ ТЭТГЭМЖ, ДЭМЖЛЭГ		500,000.00	2,000,000.00
	Нэг удаагийн тэтгэмж		500,000.00	2,000,000.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН		1,950,618,294.09	1,544,311,704.01
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	(1,797,978,928.81)	-1,461,090,994.01
	Хөрөнгийн орлого			0.00
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого			0.00
	Бусад хөрөнгийн борлуулалтын орлого		-	0.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		-	0.00
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал		51,493,760.00	13,891,000.00
	Гадаад зөвлөхийн зардал		1,508,683,240.21	428,901,602.82
	Судалгаа, шинжилгээний зардал		1,361,369,002.00	401,270,600.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (V)	-	2,921,546,002.21	844,063,202.82
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(VI)=(IV)-(V)	-	(2,921,546,002.21)	-844,063,202.82
	САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	4,689,324,422.90	1,633,293,254.70
	Авсан зээл		4,689,324,422.90	1,633,293,254.70
	Төлсөн зээл		-	0.00
	САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VIII)	-	4,689,324,422.90	1,633,293,254.70
	НИИТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX)=(VII)+(VIII)		(30,200,508.12)	-671,860,942.13
	мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,124,931,848.53	1,094,731,340.41
	мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,094,731,340.41	422,870,398.28